# ШИНЭСТ ХК

ШИНЭСТ ХК

Бүртгэлийн дугаар: 2018942
МОД БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР
Хан-Уул дүүрэг, 3-р хороо
Чингисийн өргөн чөлөө, Улаанбаатар, Монгол улс
Утас:+976-99066093; 70114414
И-мэйл: shinest@chono.mn

2019 оны 02-р сарын 28-ны өдөр Дугаар 03/04 Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ

## ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

"Шинэст" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэж, олонхийн саналыг үндэслэн Тогтоох нь:

1. Компанийн 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Хан Уул дүүргийн компанийн өөрийн байранд 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 10 цагт зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
    1. Компанийн 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан
    2. Аудитын хорооны тайлан дүгнэлт
    3. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2019 оны цалин урамшуулал болон зардлын төсөв
    4. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
    5. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэх
    6. Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрлийг ТУЗ-д олгох
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөр тогтоосугай.

4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар мэдээг 2019 оны 03 дугаар сарын 04-ны өдөр, өдөр тутмын 2-оос доошгүй сонин, телевиз болон орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радиогоор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисс /Б. Золжаргал/-т даалгасугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг хоёрдугаар

Бүртгэлийн дугаар: 2018942
МОД БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР
Хан-Уул дүүрэг, 3-р хороо
Чингисийн өргөн чөлөө, Улаанбаатар, Монгол улс
Утас:+976-99066093; 70114414
И-мэйл: shinest@chono.mn


хавсралтаар баталсугай. 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд Шинэст ХК-нийн өөрийн байранд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Золжаргал/-с авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудасны загварыг гуравдугаар хавсралтаар баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчээс "Санал авах хуудас"-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харъяалагдах брокер, дилерийн компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 5-с доошгүй хоногийн өмнө байхаар тогтсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Б.Түмэндэлгэр, гишүүдээр Б.Золжаргалнарыг тус тус томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Б. Түмэндэлгэр, тооллогын комиссын даргаар Шинэст ХК-ний Ерөнхий нягтлан бодогч Б.Золжаргал гишүүдээр Т. Оюунтүлхүүр нарыг тус тус томилсугай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга: ....................................../Б.Бурмаа/

*Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 2*
*дугаар сарын 28- ны өдрийн 03/04дугаар*
*тогтоолын "Хавсралт-1"*

*Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугээр тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, түүнд хяналт тавих зохицуулалтын журам"-ын 1 дүгээр хавсралт*

## ХУВЬ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

| | |
|---|---|
| Компаний нэр : | "Шинэст" ХК |
| Хурал хуралдах өдөр,цаг: | 2019 оны 4-р сарын 26 ны өдөр 10цаг 00минут |
| Хурал хуралдах газар: | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Эв Нэгдэлийн гудамж, Шинэст ХК, өөрийн байр |
| Хурлын төрөл: | Ээлжит хурал |
| Хурал зарлагч: | Төлөөлөн удирдах зөвлөл |
| Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо: | 2019-02-28 |
| Олон нийтэд зарлах огноо: | 2019-03-04 |
| Бүртгэлийн өдөр: | 2019-03-20 |
| Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер,диллерийн компанид хүргүүлэх огноо: | |
| Хүргүүлсэн огноо: | |
| Хурлын дарга: | Б.Түмэндэлгэр |
| Тооллогын комиссын дарга,гишүүдээр: | Дарга: Б. Золжаргал, Гишүүн : Т.Оюунтүлхүүр |
| Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/: | 1. Хурал хуралдуулах тухай ТУЗ-н шийдвэр,<br>2. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загвар,<br>3. ТУЗ-н хурлын тэмдэглэл |
| Баримт бичгийн хуудасны тоо: | хуудас |

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

................................./Б. Золжаргал /

*Дээрх мэдээллийг, хавсралт материалын хамт 2 хувь үйлдэж Санхүүгийн зохицуулах хороо, "Монголын хөрөнгийн бирж" ХК-д тус тус илгээнэ.*

# ШИНЭСТ ХК

ШИНЭСТ ХК

Бүртгэлийн дугаар: 2018942
МОД БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР
Хан-Уул дүүрэг, 3-р хороо
Чингисийн өргөн чөлөө, Улаанбаатар, Монгол улс
Утас:+976-99066093; 70114414
И-мэйл: shinest@chono.mn


---

2019 оны 02-р сарын 28-ны өдөр Дугаар 03/05 Улаанбаатар хот

## КОМПАНИЙН 2018ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ, АУДИТЫН ХОРООНЫ ТАЙЛАН ДҮГНЭЛТИЙН ТУХАЙ

"Шинэст" ХК нь "Компанийн тухай хууль"-ийн 76.1.11 дахь заалт, ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн Тогтоох нь:

1. Компанийн 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон аудитын хорооны тайланг хангалттай гэж үзсүгэй.
2. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитын хорооны тайланг дүгнэлтийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцүүлэхийг ТУЗ-ийн дарга Д.Бурмаа-д даалгасугай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга: ............................../Д.Бурмаа/